



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 346

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 145,300,000.00 (нэг зуун дөчин таван сая гурван зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий 3 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Баасандорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагаар худалдах ажлын хэсэг томилж, холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэст ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР

0000649

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн
346 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР
ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, марк, бүртгэл, арлын дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1. Сүхбаатар аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс							
1	Ландкрузер-80, 44-20 СУА (HJDJ810045809)	2012	367822	29,300,000.00	29,300,000.00	-	5,000,000.00
	Дүн			29,300,000.00	29,300,000.00		5,000,000.00
2. Өвөрхангай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс							
2	X trial, 11-23 ӨВР (арал JN1TANT31Z0101621)	2012	96221	58,000,000.00	58,000,000.00	-	2,900,000.00
	Дүн			58,000,000.00	58,000,000.00		2,900,000.00
3. Ховд аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс							
3	X trial, 97-97 ХОУ (арал JN1TANT31Z01016335)	2012	210000	58,000,000.00	58,000,000.00	-	2,900,000.00
	Дүн			58,000,000.00	58,000,000.00		2,900,000.00
	Нийт дүн			145,300,000.00 (нэг зуун дөчин таван сая гурван зуун мянган)	145,300,000.00 (нэг зуун дөчин таван сая гурван зуун мянган)		10,800,000.00 (арван сая найман зуун мянган)